

МОНГОЛ, ХЯТАДЫН ОРЧИН ҮЕИЙН ХОТЖИЛТЫН ҮЙЛ ЯВЦЫН ОНЦЛОГ

Ж. Баттөр*

***Abstract:** In this article, author did some analyzes on Mongolian and Chinese urbanization process, which is taking place in two countries simultaneously, also which is bring tremendous problems including housing, migration, job market, air pollution and traffic congestion. Author emphases there are huge needs to Mongolia and China to acquire the modern urban management technology. Also reviewed Chinese policy and special measures for solving of urbanization issues, pressures and challenges.*

***Key words:** Urbanization in Mongolia and China, Housing, Migration, Air Pollution*

* * *

2014 онд НҮБ-аас “Дэлхийн хотжилтын төлөв” (World Urbanization Prospect) хэмээх тайлан илтгэл нийтлэгдсэн бөгөөд энд дурдсанаар “Дэлхийн хэмжээгээр эдүгээ нийт хүн амын 54 хувь буюу хөдөө орон нутгаас хотод илүү олон хүн оршин сууж байгаа”-г тэмдэглэсэн байна. Мөн 2050 он гэхэд дэлхийн нийт хүн амын 66 хувь нь хотод оршин сууна гэсэн буй.¹⁹⁹

Уг тайлан илтгэлд дурдсанаар “Дэлхийн хүн амын хамгийн том өсөлт Энэтхэг, Хятад, Нигерид болно... Энэ гурван улсад 2014-2050 оны хооронд дэлхийн хүн амын дурдсан өсөлтийн 37 хувь нь ногдоно. 2050 он гэхэд Энэтхэгт хотын хүн ам 404 саяар, Хятад 292 саяар, Нигерид 212 сая хүнээр тус тус нэмэгдэнэ”²⁰⁰ гэжээ.

Монгол Улсад болон БНХАУ-д өнөө цаг үед өрнөж буй нэгэн түүхэн томоохон бүтээн байгуулалт бол хотжилтын үйл явц мөн. Энэхүү өгүүлэлд манай хөрш орны судлаачдын анхаарлыг энэ чиглэлд хандуулан хоёр орны хотжилтын талаарх бодлого хийгээд хэрэгжилтийн талаар хамтран судлах шаардлага бийг нотлон өгүүлэхийг чармайсан билээ.

Монгол Улс хийгээд БНХАУ-д өнөөдөр хотжилтын үйл явц ид эрчимтэй өрнөж байна. Нэн олон ард иргэгдийн амьдралд шууд нөлөөлж, улс орны эдийн засаг, хөрөнгө оруулалт, ирээдүйн төлөв байдалтай асар их хамаарал, нөлөө үзүүлэх энэ үйл явц нь судлаач бид бүхний хувьд хойшлуулж болшгүй судалгааны сэдэв төдийгүй, хоёр орны эдийн засгийн харилцаанд шууд нөлөөлөх асуудал тул цаашдаа ч хамтран судалгаа хийх, туршлагаас хуваалцах, судалгааны үр дүнгээ ч солилцох шаардлага мөн урган гарч буйг энд цохон тэмдэглэмээр байна.

* МУИС, ОУХНУС-ийн ОУХ-ны тэнхимийн дэд проф, доктор (Ph.D)

¹⁹⁹ www.un.org/.../2014-revision-world-urbanization-prospects.ht.../2016 оны 8 сарын 15-нд үзэв./

²⁰⁰ www.un.org/.../2014-revision-world-urbanization-prospects.ht.../2016 оны 8 сарын 15-нд үзэв./

Монгол Улс дахь хотжилтын явц

Өнөөдөр та бүхэн Монгол Улсад зочлох аваас хот суурин газруудад орон сууцны барилга байгууламж нэлээд эрчимтэй баригдаж буйг харж болох бөгөөд ялангуяа нийслэл Улаанбаатар хотоос ийм бүтээн байгуулалтын эрчмийг тодорхой харж мэдэрч болно. Улаанбаатар хотын барилгажилт, хотжилтын үйл явцыг ярихаас өмнө зайлшгүй үүх түүхтэй нь танилцах хэрэгтэй болов уу гэж бодож байна.

Монголчууд хэдийгээр нүүдэлчин, малчин ард түмэн байсаар ирсэн ч нэн эртнээс өөрийн гэсэн өвөрмөц хот балгад, суурин төв газрууд байгуулсаар ирсэнийг бид мэднэ. Энэ талаарх түүх, археологийн судалгаа улам бүр гүнзгийрсээр байна. Энд бид Хархориноос эхлээд Дайду, Шанду гээд үргэлжлүүлэн нэрлэж болно. Харин одоогийн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот нь анх Монголын шарын шашны анхны тэргүүн Занабазартай холбогддог юм. Учир нь Халхын ноёд Занабазарт зориулан одоогийн Өвөрхангай аймгийн Бүрд сумын Ширээт цагаан нуурын хөвөөнд байгуулсан “Шар бүсийн хот” хэмээх өргөө байгуулж өгсөн нь төв суурин болж яваандаа Улаанбаатар хотын үндэс болсон юм.

Улаанбаатар нь байгуулагдсан цагаас хойш 1639-1778 онд 28 удаа нүүдэллэж Өргөө, Номын өргөө, Их хүрээ, Нийслэл хүрээ гэж нэрлэгдэж байжээ. Монголчууд одоогийн Улаанбаатар хотыг товлон суурьшсан он цаг нь 1778 он юм. Харин Монгол Улсын нийслэл үүнээс өмнө 100 гаран жил томоохон аян жингийн байдлаар нүүдэллэж бууриа 20 орчим удаа сэлгэсэн гэдэг. Нийслэл хот маань тийнхүү 1778 оноос одоогийн энэ байгаа Богд хан уулын ард, Туул голын хөвөөнөө суурьшсан байдаг. 1911 оны 12-р сарын 31-нд Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж, Монголын улс төр, эдийн засаг, соёл, шашны төв Их хүрээг хаант Монгол Улсын “Нийслэл хүрээ” хэмээн тунхагласан. 1924 онд хуралдсан Улсын анхдугаар хурлаас Нийслэл хүрээг улсын нийслэл болгон “Улаанбаатар” хэмээн нэрлэсэн юм.

XX зууны эхэн үеэс шашны хийгээд төр нийгэм, эдийн засгийн гол төв болсныг 100 гаруй сүм хийдтэй, 600 гаран дэлгүүр хоршоо, 350 орчим одоогийнхоор үйлчилгээний дэлгүүр мухлаг байсан гэсэн баримтаас харж болно.²⁰¹

Монголчууд мал аж ахуйгаа эрхлэн нүүдэллэн аж төрөх уламжлалтай ард түмэн тул тухайн үеийн хотын иргэдийн дийлэнх нь лам нар, Хятад болон бусад орны худалдаачид байсан юм. Тэр үеийн нийслэл хот багцаагаар 20,000 орчим оршин суугчтай байжээ.

1940-өөд оноос Улаанбаатар хот тэлж эхлэн, 1954 онд анхны хотын хөгжлийн төлөвлөгөө буюу одоогийнхоор цогц төлөвлөгөөгөө батласан байдаг. Энэ үеэс хотын хил хязгаар, район дүүргүүдийг тогтоосон байна. Түүнээс хойш хот хөгжүүлэх төлөвлөгөөг хэд хэд нарийвчилан гаргасаар ирсэн юм.

²⁰¹ MPR: Information Mongolia, Academy Sciences of Mongolia, 1990. Oxford: Pergamon Press.
Ricardo Neupert, Sidney Goldstein, “Urbanization and Population Redistribution in Mongolia” East-West Center Occasional Papers, Population series, No,122, December 1994. Honolulu, Hawaii.

Улаанбаатар нь Монгол Улсын нийслэл бөгөөд Баянзүрх, Баянгол, Налайх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул, Багануур, Багахангай гэсэн 9 дүүрэгт хуваагддаг. Дүүрэг бүр нь хороодод хуваагдана. Хотыг 4 жил тутамд хотынхоо иргэдээс сонгогддог Иргэдийн төлөөлөгчдийн хурал удирдах бөгөөд Иргэдийн төлөөлөгчдийн хурал хотын даргын нэрийг дэвшүүлж Монгол Улсын Ерөнхий сайдад өргөн барьдаг бөгөөд Ерөнхий сайд бүрэн эрхийн хүрээнд хотын даргыг 4 жилийн хугацаатайгаар томилдог. Улаанбаатар нь Монгол Улсын нутгийн 0.3% -ийг эзлэх боловч нийт хүн амын 40 гаруй хувь нь, хот суурин газрын хүн амын 65% оршин суудаг. 2014 оны байдлаар Улаанбаатар хотын хүн ам нь 1,324,000 бөгөөд нягтшил нь квадрат километр тутамд 300 хүн ноогдож байна.

Нийт хотын хүн амын 67%-ийг 35-аас доош насны залуучууд эзэлдэг бөгөөд үүнээс 30% нь 16-аас доош насны хүүхдүүд байна. 2007 оны 4-р сард 1.0 сая хүнтэй болж дэлхийн саятан хотуудын 182 дугаарт, Азийн саятан хотуудын 107 дугаар жагсаалтад бичигдэх болжээ. Нийслэлийн хүн амын дундаж наслалт 70.8 болсон. Хотын хүн амын өсөлтийн 66% дотоодын шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэй. Нийслэл хотод жилд дунджаар 16 мянган хүүхэд шинээр төрдөг. Улаанбаатар хотод 2009 оны 1-р сарын байдлаар 251.8 мянган өрх айл оршин сууж, нийт өрхийн 60.6% гэр хороололд, 39.4% орон сууцад амьдарч байна. Нийслэлийн нэг өрхийн сарын дундаж орлого 2012 оны байдлаар 983.2 мянган төгрөг болж, өмнөх жилүүдээс өссөн үзүүлэлттэй болжээ.²⁰²

Улаанбаатар хотын гол сорилтууд

Нийслэл Улаанбаатар хотын хувьд хэд хэдэн амаргүй бэрхшээл сорилтууд байна. 1992 онд баталсан МУ-ын Үндсэн хуулийн дагуу Монгол Улсын иргэн амьдрах газраа өөрөө сонгох эрхтэй болсон. МУ-д макро түвшинд авч хэрэгжүүлж байгаа эдийн засгийн бодлогын дагуу хүмүүс хөдөө рүү шилжих ёстой байтал 1992 оноос хойш УБ хот руу шилжих хөдөлгөөн нэмэгдсэн. МУ-ын 2000 оны хүн ам орон сууцны тооллогын дүнгээр, шилжих хөдөлгөөн 1989-2000 оны хоорондох 11 жилийн хугацаанд өмнөх 1979-1989 оны хоорондох 10 жилийн хугацаатай харьцуулахад хоёр дахин нэмэгдсэн. Цаашилбал, 2010 оны хүн ам орон сууцны тооллогоор УБ хот руу МУ-ын өнцөг булан бүрээс чиглэсэн урсгал 2000-2010 онд хоёр дахин нэмэгдсэн. 2000 онд УБ хотод амьдарч байгаа гурван хүний нэг нь шилжин ирэгч байсан бол 2010 онд хоёр хүний нэг нь шилжин ирэгчид байна. Дотоодын шилжих хөдөлгөөний энэ эрчимтэй үйл явц цаашид саарахгүй, үргэлжлэх шинжтэй байна. 2020 онд УБ хотод гурван хүний хоёр нь шилжин ирэгчид болох магадлалтай юм.²⁰³

1. Хүн амын хэт төвлөрөл

Өнөөдөр Монголын нийт хүн амын бараг тал хувь нь Улаанбаатарт аж төрж байна. Яагаад ийм байдалд хүрсэн бэ гэвэл дараах хэдэн шалтгаантай юм. Юуны

²⁰² www.edub.edu.mn/v/2015-10-21-1/Улаанбаатар хот үүсч хөгжсөний 376 жилийн ойд /

²⁰³ Монгол Улсын шилжих хөдөлгөөний үндэсний хөтөлбөр 2016- 2020” – төсөл, НҮБ

түрүүнд 1990 онд Монгол Улс шинэ “Үндсэн хууль”-иа баталсан. Үндсэн хуулийн 16-р бүлгийн 18-р зүйлд ийм нэгэн заалт бий.

“Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: гээд Монгол Улсын иргэний эдлэх голлох эрх, эрх чөлөөг жагсаасны дотор 18-д

- *улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.” гэсэн буй.*²⁰⁴

Өөрөөр хэлбэл, улсынхаа нутаг дэвсгэр дээр чөлөөтэй түр олон байнга оршин суух газраа сонгох гэсэн заалтаар 1990 оноос өмнө байсан нийслэл хотод оршин суухад зарим төрлийн хязгаарлалт хийдэг байсан журам хүчингүй болсон юм. Иймээс нийслэл хот руу иргэд олноороо нүүн ирэх үүдийг нээсэн болно.

2. Байгалийн гамшигт үзэгдлүүд

1992, 1996, 2001, 2011 онуудад Монгол Улсын дийлэнх болон хэсэг бүс нутгуудад зуд болж олон сая мал хөлдөж үхсэнээр малгүй өөрөөр хэлбэл амьжиргааны орлогын эх үүсвэргүй болсон малчид Улаанбаатар хот руу үй олноороо нүүж ирэх үндсэн шалтгаан болсон юм. Мөн хөдөө орон нутгийн ихэнх үйлдвэр аж ахуйн газрууд өрсөлдөх чадваргүй болж дампуурч, эсвэл татан буугдсан, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг халсан явдал ч томоохон нөлөө үзүүлсэн билээ. Эндээс үүдэн олон хүн ажилгүй болж хот руу нүүж ажлын байрны эрэлд гарсан байдаг.

Түүнчлэн малыг хувьчилснаар малын тоо толгой асар хурдан өсөж, одоо 60 сая гаран малтай болоод байгаа нь бэлчээрийн хомсдолд хүргэж, цөөн малтай байх нь ашиг багатай болж цөөн малтай иргэд нэг бол олон малтай баян чинээлэг малчинд ажиллаж амьжиргаагаа залгуулах, нэг бол малаа зарж хот руу нүүх гэсэн хоёр сонголт үлдэж дийлэнх нь хот руу нүүсэн юм.

3. Агаарын бохирдол

Монгол Улс эрс тэс уур амьсгалтай өвөлдөө хасах 40, 50 хэм хүртлээ хүйтэрдэгийг та бид бүгд мэднэ. Энэ их хүйтэнд тэсч байхын тулд заавал нүүрс түлдэг. Нүүрсний утаа ихсэхээр маш их агаарын бохирдолд хүргэж байгаа юм. Агаарын бохирдол нь хотжилтоос бус асуудлыг шийдвэрлэж чадаагүйн уршиг гэж хэлж болно. Агаарын бохирдлоос гадна хөрсний, улмаар ундны усны, тоосжилтын асуудлууд бий бөгөөд эдгээр нь бие даасан асуудлууд учир тусгайлан судлах шаардлагатай гэж бодож байна.

4. Дотоод шилжих хөдөлгөөний урсгалууд

УБ хот, Төвийн бүс рүү чиглэсэн урсгал 2000 оноос хойш явагдаж байна. Орхон, Дархан-Уул, Говь-Сүмбэр, Сэлэнгэ гэсэн төмөр замтай аймгууд мөн Төв аймаг

²⁰⁴ www.legalinfo.mn

руу чиглэсэн урсгал нэмэгдсээр байна. Уул уурхайн салбарыг тэргүүлэх чиглэл болгосонтой холбоотойгоор Өмнөговь, Дорноговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал шинээр үүссэн. Бүс нутаг доторх шилжих хөдөлгөөнийг авч үзэхэд Ховд болон Чойбалсан хот руу чиглэсэн урсгал байна.

5. Монгол Улсын дотоод шилжих хөдөлгөөний онцлог

Монгол Улсын уламжлалт хөдөө аж ахуйн салбар нь газар тариалан биш харин нүүдлийн мал аж ахуй учраас ихэнх Монголчуудад газар тариалан эрхлэх, газартай харьцах соёл төлөвшөөгүй, малаараа дамжин газартай холбогддог учраас малгүй болоход, гэрээ аваад оршин суугаа газраасаа нүүхэд амархан байдаг. Энэ нь дотоод шилжих хөдөлгөөний эрчимтэй өсөлтийн “бүтцийн” шалтгаан болж байна. Газар тариалан эрхэлдэг дэлхийн ихэнх улс орнуудад газар тариалан эрхлэхээ болиод, газраа хоосон орхиод нүүх үзэгдэл байхгүй, зөвхөн “газаргүй” тариачдын шилжих хөдөлгөөн байдаг.²⁰⁵

6. Улаанбаатар хотын төвлөрөл

2010 оны байдлаар хүн амын 65 хувь нь УБ хотод амьдарч байна. УБ хот руу чиглэсэн урсгалын үр дүнд УБ хотод эдийн засгийн бүтцийн өөрчлөлт болон хөгжилтэй уялдаагүй хэт төвлөрөл үүсч байна. УБ хотод шилжин ирэгчдийг хамгийн их хүлээн авч байгаатай холбоотойгоор бохирдол гаарч, авто зам, дэд бүтцийн ачаалал нэмэгдсэн. Шилжин ирэгчдээс шалтгаалан гэр хороолол тэлж, агаарын бохирдол гамшгийн хэмжээнд хүрсэн. Гэр хороололд дэд бүтэц шийдэгдээгүй учир хөрсний бохирдол улам бүр нэмэгдэж, ялангуяа үер буух үед мөн гамшгийн хэмжээнд хүрдэг. УБ хотын байгаль орчны байдал доройтож байна. Нэг км квадрат нутаг дэвсгэрт ногдох нягтрал нэмэгдэж, бохирын байгууламж ачааллаа даахаа больсон. Мөн УБ хотын авто замын зохион байгуулалтаас шалтгаалан авто замын түгжрэл нэмэгдсэн.

УБ хотод төвлөрөл нэмэгдсэн нэг шалтгаан нь дунд зэргийн хотын хөгжлийг эдийн засгийн хөшүүргээр дэмжихгүй байгаатай холбоотой. Аливаа улсын нийслэл, үндэсний хэмжээний том хотууд бол санхүү, бизнесийн төв байдаг. Харин дунд зэргийн хотод аж үйлдвэрийг хөгжүүлсэн байдаг. МУ-ын хотжилтийн бүтэц тогтолцоонд УБ хотоос өөр үндэсний түвшний хот байхгүй, дунд зэргийн хот алга байна.²⁰⁶

7. Хүн амын тархан суурьшилт

МУ-ын хүн ам нутаг дэвсгэрийнхээ хойд хэсгээр, УБ хот, төвийн бүс, төмөр замтай аймгуудыг түшиглэн тархан суурьшиж байна. Харин баруун болон зүүн бүс нутаг шилжигчдийг хамгийн олноор илгээж байна. Аливаа нутаг дэвсгэрээс хүмүүс шилжин явахад тэдэнтэй хамт хөрөнгө мөнгө, бараа бүтээгдэхүүн, зах зээл хамтдаа нүүж явдаг. Хүн шилжин явснаар тухайн орон нутагт хөдөлмөрийн нөөц хомсдож, зарим газар эзгүйрч байна. Ялангуяа, баруун бүс, зүүн бүс болон

²⁰⁵ Монгол Улсын шилжих хөдөлгөөний үндэсний хөтөлбөр 2016- 2020” - төсөл

²⁰⁶ Монгол Улсын шилжих хөдөлгөөний үндэсний хөтөлбөр 2016- 2020” - төсөл

(Өмнөговь, Дорноговь аймгийг эс тооцвол) говийн бүс нутгаар хүн амын тархан суурьшилт улам бүр багасч байна.

8. Шилжих хөдөлгөөний шалтгаан

Шилжих хөдөлгөөний хүчин зүйлийн онолоор, илгээж байгаа газрын түлхэх хүч, хүлээн авч байгаа газрын татах хүч гэсэн үндсэн хоёр бүлэг хүчин зүйлээс шалтгаалж хүмүүс шилжих хөдөлгөөнд ордог. МУ-ын хувьд татах хүч биш харин түлхэх хүч илүү үйлчилж байгаа. Өөрөөр хэлбэл, хэрэв түлхэх хүч үйлчлээгүй байсан бол хүмүүс төрж өссөн нутгаас олноороо нүүж, “гэр бүлийн урсгал” зонхилохгүй байсан. Харин зөвхөн татах хүчинд хариу үйлдэл үзүүлсэн, үргэлжлүүлэн суралцах залуучууд, орон нутагтаа байхгүй мэргэжил эзэмшсэн хүмүүс зэрэг “ганц бие хүмүүсийн урсгал” зонхилох байсан. Шилжих хөдөлгөөний түлхэх хүч гэдэг нь хүмүүс ажилгүй болж, амьжиргаагаа алдаж, амьжиргаа нь баталгаагүй болно гэсэн үг юм. МУ-д явуулсан шилжих хөдөлгөөний судалгаанаас харахад шилжигчид байнгын ажил байхгүй, малаа алдсан, ажлын байр байхгүй, цалин бага, орлого бага гэсэн шалтгааныг голлон хэлсэн байдаг. Цаашилбал, “түлхэх хүч” нь “татах хүч”-ээс илүү хүчтэй үйлчилж байна. Тиймээс, тухайн орон нутаг дахь “түлхэх хүч”-ийг арилгах нь шилжих хөдөлгөөний буурахад нөлөөлнө.

Шилжих хөдөлгөөний эдийн засгийн “түлхэх хүч”-ээс гадна сургууль, эмнэлгийн үйлчилгээний чанар, засаглал, шудрага бус байдал зэрэг нийгмийн “Түлхэх хүч” үйлчилдэг. Шилжих хөдөлгөөний талаар хийсэн судалгааны үр дүнгээс харахад МУ-д сургууль, цэцэрлэгийн чанар муу, эмнэлгийн үйлчилгээний чанар муу, нам болон талцаж ажил олдохгүй байна зэрэг нийгмийн түлхэх хүч үйлчилж байна. Нийгмийн түлхэх хүч дотор орон нутагт “ирээдүй байхгүй” гэсэн шалтгаан байгаа нь орон нутагт зах зээл багасч, бизнесийн орчин бүрдэхгүй, улам муудаж, амьдрал бужигнахгүй эзгүйрч байгааг илэрхийлж байна. Энэ нь хүн амын тархаан суурьшлын бодлого байхгүй байгаатай холбоотой.

9. Албан бус ажиллагчдын урсгал

2000, 2010 оны хүн ам орон сууцны тооллогын дүнгээр, МУ-ын нийт ажиллагчдын 1/4-ээс илүү нь албан бус ажиллагчид болж, албан бус ажиллагчдын “анги” бий болжээ. Албан бус ажиллагчдыг хөдөөгийн малчдаас гадна хот суурин газарт хувиараа худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид, мөн өрхийн болон хувийн аж ахуйд ажиллагчид бүрдүүлж байгаа. Аж үйлдвэрийн салбарыг дэмжээгүй байхад хүмүүс олноороо хотод ажиллахаар ирж, үйлдвэрийн газар, албан секторт ажиллах ажлын байр хангалтгүй учраас хувиараа хөдөлмөр эрхэлж, хөдөөгөөс хот руу чиглэсэн албан бус ажиллагчдын урсгал нь шилжих хөдөлгөөний үндсэн урсгалын нэг болж байна.

10. Нөөц ажиллагчдын урсгал

2000, 2010 оны хүн ам орон сууцны тооллогын дүнгээр, ажилгүйдлийн түвшингийн өргөтгөсөн тодорхойлолтоор, ажиллах хүчний 1/4 орчим нь нөөц

ажиллагчид болж, нөөцажиллагчдын “анги/арми” үүссэн байна. Нөөцажиллагчдыг, эрүүл саруул, хөдөлмөрийн насны ажил хийхгүй байх шалтгаангүй, хөдөөд малаа алдаж, улсын болон хувийн хэвшилд ажиллахад цалин бага, албан бус секторт ажиллахад зах зээлийн хэмжээ, бизнесийн орчны эрсдэл зэрэг шалтгааны улмаас амьжиргаагаа алдаж (entitlement failure), эрдэлд учирч хүмүүс бүрдүүлж байна. Хөдөө орон нутагт амьжиргаа нь эрдэлд орсон хүмүүс ажил, амьжиргаа эрэлхийлж хот суурин газар руу шилжин ирсэн ч ажил олдохгүй, ажил хийхгүйн улмаас амьдрал нь эрсэлтэй болсон, хөдөөгөөс – хот руу чиглэсэн нөөц ажиллагчдын урсгал нь шилжих хөдөлгөөний үндсэн урсгалын бас нэг болж байна.

Шилжих хөдөлгөөний талаарх судалгаанаас харахад ажилгүй, ядуу хүмүүс хөдөөнөөс хотод шилжиж ирсний дараа “иргэний ухамсар” муу байгаагийн улмаас УБ хотын “иргэн” гэж бүртгүүлэхгүй байна. Цаашилбал, “бүртгэлгүй” байгаа нь тэдний ажил амьдралыг эрсдэлд оруулж байна.

Гарах арга зам

Эдгээр бэрхшээлийг давах туулахын тулд Улаанбаатар хотын захиргаанаас явуулж буй тодорхой арга хэмжээнүүдээс энд жишээ болгож дор гэр хорооллын дахин төлөвлөлтийн тухай товч өгүүлбэр. Учир нь энэ арга хэмжээ ихээхэн шинэлэг бараг цорын ганц арга болж буйгаараа онцлогтой билээ.

Гэр хорооллын дахин төлөвлөлт

Гэр хорооллыг байршил, инженерийн дэд бүтцийн сүлжээнд холбох боломж, орон сууцны нөхцөлөөр нь төв, дунд, зах хэмээн төлөвлөлтийн гурван бүсэд хувааж, шинэчлэн зохион байгуулж дахин төлөвлөнө. Үүнд:

1. Инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох боломжтой төвийн гэр хорооллыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөж, өндөр болон дунд давхаржилттай олон нийт, орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ.
2. Дунд хэсгийн гэр хорооллыг хэсэгчилсэн болон бие даасан инженерийн шугам сүлжээнд холбосон, дунд, нам давхрын сууцны хороолол болгон хөгжүүлнэ.
3. Захын гэр хорооллын хэсэгт газрыг шинэчлэн зохион байгуулж, бие даасан дэд бүтэц бүхий нам давхаржилттай хувийн сууцны хороолол болгон байгуулна.

Гэр хорооллыг дахин төлөвлөж, сайжруулах стратеги

Төр, хувийн хэвшил, иргэдийн харилцан итгэлцэл, хамтын ажиллагаанд тулгуурлан:

- Гэр хорооллын хувьчилсан эдэлбэр газрыг эздийнх нь шууд оролцоотойгоор дахин төлөвлөж, газрыг зүй зохистой ашиглах хот байгуулалтын үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх

- Гэр хорооллын дэд, бичил төвүүдийг хөгжүүлэх
- Ногоон химид суурилсан, цэвэршүүлэх, хаягдалгүй технологийн хөтөлбөрт арга ажиллагааг хэрэгжүүлэн, хүрээлэн буй орчны бохирдлыг арилгаж, хохирлыг багасгах
- Өрхийн болон хоршооны үйлдвэрлэлд үндэслэсэн хөгжлийн хөтөлбөрөөр бие даан хөгжих боломж нөхцөлийг бүрдүүлэх
- Иргэдийн худалдан авах чадварт нийцсэн төрөл бүрийн орон сууцыг нийлүүлэх зэргээр суурин амьдралын нөхцөл стандартыг бүрэн хангасан Монгол дүр төрх бүхий өвөрмөц суурьшлын шинэ хорооллуудыг бүтээн байгуулна.²⁰⁷

Нийслэл 2016 оны төсөвтөө тодотгол хийж, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажилд 20 тэрбум төгрөгийг нэмж зарцуулахаар болжээ. Гэхдээ хөрөнгө оруулалтын мөнгийг 2015 оны төсвийн орлого давж биелсэн 11 тэрбум 159.9 сая, ашиглаагүй үлдэгдлээс хоёр тэрбум 570 сая, энэ оны урсгал зардлын хэмнэлтээс гарсан дөрвөн тэрбум 580 сая төгрөг зэргээс бүрдүүлнэ гэжээ. Гурван жилийн өмнөөс эхэлсэн гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд барилгын “38 компани найман дүүргийн 37 хорооны нутаг дэвсгэрийн 1500 га газарт 7374 айлын орон сууц барьж байна.” Үүнээс 2014 онд 588, өнгөрсөн жил 1069 айлын орон сууц шинээр ашиглалтад оржээ. Мөн 500 өрхийн 2100 иргэн хашаагаа байраар солиод буй юм. Харин 2016 ондоо багтан гэр хорооллын хашаа байсан газарт 4044 айлын орон сууц ашиглалтад орохоор ажил үргэлжилж байна. Өөрөөр хэлбэл, энэ оны эхний зургаан сард 1104 айлын орон сууц бэлэн болж, 4000 орчим иргэн шинэ байранд орсон юм. Мөн хотын удирдлагууд Нийслэлийн орон сууцны корпорацийг (НОСК) хувьцаат компани болгон өөрчилж, гэр хорооллын дахин төлөвлөлтөд хэрэгтэй мөнгө босгохоор тооцжээ. Давхар үнэт цаас гарган зах зээлээс хүү багатай, хугацаа урттай хөрөнгө санхүү татах эрхтэй болгохоор бэлдэж буйгаа тодотголоо.

Нийслэлийн төсвийн 20 тэрбум төгрөг болон банкууд НОСК-ийн үнэт цаас худалдан авсанаар бүрдэх эх үүсвэр илүү хямд болох юм байна. Нөгөө талдаа Улаанбаатар хотын агаар, хөрсний бохирдол зэргийг бууруулах нэг гарц болно гэж хотын дарга асан Э.Бат-Үүл тайлбарлаж байжээ.²⁰⁸

Гурван жилийн өмнө эхэлсэн Гэр хорооллыг дахин төлөвлөх төсөл нийслэлийн хүн амын 9 хувь, нутаг дэвсгэрийн 14 хувийг хамарчээ. Өнөөдрийн байдлаар 22 байршлын 58 хэсэгчилсэн талбайд уг төсөл хэрэгжиж, айл өрхүүд орон сууц барих компани олонхын саналаараа сонгон шалгаруулж, гэрээ байгуулан газраа чөлөөлж буй юм. Өнгөрсөн гурван жилийн хугацаанд 38 компани найман дүүргийн 37 хорооны нутаг дэвсгэрийн 1500 га газарт 7374 айлын орон сууц барьж эхэлжээ. Үүнээс 2014 онд 588, өнгөрсөн жил 1069 айлын шинэ орон сууц ашиглалтад орж, газраа чөлөөлсөн айлууд байртай болсон байна. Мөн 500 өрхийн 2100 иргэн

²⁰⁷ Монгол Улсын шилжих хөдөлгөөний үндэсний хөтөлбөр 2016- 2020” - төсөл

²⁰⁸ Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага. Улаанбаатар хот. 2014.

хашаагаа байраар солиод байгаа аж. Энэ онд л гэхэд гэр хороолол байсан газарт 4044 айлын орон сууц сүндэрлэж, төдий тооны айл шинэ байранд орох юм.²⁰⁹

2015 оны байдлаар

№	Аймаг	Шилжин явсан	Шилжин ирсэн
1.	Улсын дүн	53,684	53,912
2.	Баруун бүс	8,329	2,564
3.	Баян-Өлгий	1,328	262
4.	Говь-Алтай	1,423	386
5.	Завхан	2,073	703
6.	Увс	1,799	547
7.	Ховд	1,706	666
8.	Хангайн бүс	13,038	6,351
9.	Архангай	1,706	637
10.	Баянхонгор	1,614	545
11.	Булган	1,800	1,072
12.	Орхон	3,263	2,374
13.	Өвөрхангай	2,639	849
14.	Хөвсгөл	2,016	874
15.	Төвийн бүс	15,905	11,194
16.	Говьсүмбэр	677	799
17.	Дархан-Уул	3,677	2,306
18.	Дорноговь	1,912	1,505
19.	Дундговь	792	1,152
20.	Өмнөговь	1,369	1,130
21.	Сэлэнгэ	3,900	1,999
22.	Төв	3,578	2,303
23.	Зүүн бүс	4,710	3,506
24.	Дорнод	891	698
25.	Сүхбаатар	900	905
26.	Хэнтий	2,919	1,903
27.	Улаанбаатар	11,702	30,297 ¹
28.	Улаанбаатар	11,702	30,297 ¹³

Хятад улс дахь хотжих үйл явц:

БНХАУ дахь хотжилт нь өөрөө асар том үйл явц юм. Зарим судлаачийн үзсэнээр дэлхийн түүхэнд гарсан хамгийн том хотжилтын үйл явц аж.

2030 гэхэд Хятадын хотын хүн амын тоо нэг тэрбумаас давах төдийгүй, 2025 он гэхэд Хятад улс нэг саяас дээш хүн амтай 221 хот, таван саяас дээш хүн амтай 23 хоттой болох ажгуу. Гэтэл Европт нэгээс дээш хүн амтай 35 хот байдаг. (Ерөөс таван саяас дээш хүн амтай хотыг “мега хот” гэдэг.) Түүнчлэн 25 саяас дээш хүн амтай 15 супер хот босч, тус бүрдээ жараас дээш хүн амтай, эдийн засгийн сүлжээнд орсон 11 урбан кластер бий болно гэж судлаачид үзжээ.²¹⁰

²⁰⁹ www.news.mn /Д. Уламбаяр. “Дахин төлөвлөлтөнд 20 тэрбумыг нэмж зарцуулна.” 2016.05.13/

²¹⁰ www.1212.mn /2015/ Иргэдийн шилжилт хөдөлгөөн./ Улсын Бүртгэл, Статистикийн Ерөнхий Газар.

Энэ их хотжилт нэг талаас дотоодын эдийн засгийн асар их эрэлт, хөрөнгө оруулалтын боломж бий болгох авч, нөгөө талаас газар, ус, орчин ахуй, эрчим хүчний маш их нөөц, шинэ эрэлт, хэрэгцээг шаардаж байгаа юм.

Хятад улсын Намын төв сургуулиас хэвлэдэг “*Чууши*” (Үнэнийг эрэлхийлэх) хэмээх сэтгүүлийн 2012 оны дугаарт (тухайн үед шадар сайд байсан) БНХАУ-ын Ерөнхий сайд Ли Көчиан хотжилтын талаарх хэлсэн үг хэвлэгдсэн юм. “Дотоодын эрэлтийг нэмэгдүүлэн өргөтгөх хамгийн том боломж хотжилтод оршиж байна.... Статистикаас харахад хотын оршин суугч 2010 онд 15,900 юань зарцуулсан нь мөн оны хөдөөгийн оршин суугч 4,455 зарцуулсантай харьцуулахад 3,6 дахин ихийг зарцуулсан байна. Энэхүү тооноос харахад хэрвээ тариачин хотын оршин суугч болвол хэрэглээ 10,000 юаниар өснө гэж хэлж болно.”²¹¹

Улмаар 2012 оны 11-р сард болсон Хятадын Коммунист намын 18-р Их хурлаас *Шиньшин чэншихуа* (шинэ хэв маягийн хотжилт) гэсэн нэр томъёог танилцуулсан юм. Ингээд 2013 оны Коммунист намын 3-р Бага хурал дээр “Бид Хятадын онцлогтой шинэ хэв маягийн хотжилтийн үйл ажиллагааг баримтална”, үүний тулд “Бид хотын хукоу-гийн журмыг шинэчлэх ажлыг түргэсгэнэ” гэсэн байдаг.²¹² Энэ үеэс эхлэн хотуудад ажиллаж буй хөдөөгийн нүүдэл иргэд (мигрант ажилчид)-д хукоу олгох талаар арга хэмжээ авч эхэлсэн билээ.

2014 оны 3-р сард Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн 12-р Их хурал дээр Ерөнхий сайд Ли Көчиан “Засгийн газрын ажлын талаарх тайлан илтгэл”-дээ “Ард иргэдэд төвлөрсөн гэсэн шинэ хэв маягийн хотжилтын хэрэгжүүлэх”-ийг мөн оны үндсэн гол зорилт гэж тэмдэглэсэн юм. Тэрбээр Хятадын Засгийн газраас маш том зорилт тавьж буйг дараах байдлаар илэрхийлсэн: “Ирэх жилүүдэд бид хот руу нүүж ирсэн 100 сая гаруй хөдөө тосгоны ард иргэдэд хотын иргэншил олгоно... бас хөдөө тосгоны 100 гаран оршин суугчийг суурьшуулна” гэсэн юм.²¹³

Дээрх тайлан илтгэлийн дараагаас БНХАУ-ын Төрийн Зөвлөлөөс Улсын (Үндэсний) шинэ хэв маягийн хотжилтын төлөвлөгөө-г баталсан бөгөөд уг Төлөвлөгөөнд дурдсанаар 2012 оны байдлаар Хятадын нийт хүн амын 52.6 хувь нь хотын хүн ам байгаа харьцааг 2020 он гэхэд ойролцоогоор 60 хувьд хүргэж, одоогоор 35.3 хувь буй хотын хукоу бүхий оршин суугчдын харьцааг 45 хувьд хүргэнэ гэж төлөвлөсөн байна.²¹⁴

Уг төлөвлөгөө (манайхаар бол Ерөнхий төлөвлөгөө) нь нийт 31 бүлэгтэй агаад 4-р бүлэгт хотжилтын шинэ хэв маягийн шинжийн “Удирдан чиглүүлэгч үзэл

²¹¹ <http://www.mckinsey.com/global-themes/urbanization/preparing-for-chinas-urban-billion>
Jih-Un Kim “A Bumpy Road to Cities: Analysis of the Obstacles and limits of China’s New Urbanization”, Pacific Focus (Inha Journal of International Studies), Volume XXX No.3 December 2015. p. 373.

²¹² Хятадын Коммунист намын Төв Хороо, “шинэчлэлийг иж бүрнээр гүнзгийрүүлэх талаарх Зарим гол арга хэмжээний тухай Хятадын Коммунист намын Төв Хорооны шийдвэр”, Рэнминь Рибасонин, /2013 оны 11-р сарын 16-ны өдрийн дугаар/

²¹³ Ерөнхий сайд Ли Көчаний илтгэлийг http://www.gov.cn/guowuyuan/2014-03/14/content_2638989.htm/ хэмээх Хятадын Төрийн Зөвлөлийн сайтаас харж болно.

²¹⁴ Хятадын Төрийн Зөвлөл “Улсын Шинэ хэв маягийн Хотжилтын Төлөвлөгөө 2014-2020”, Рэнминь Рибасонин, 2014 оны 3-р сарын 17-ны өдрийн дугаар.

суртал”-ыг дараах байдлаар томъёолсон байна. Үүнд:

1. *Ирэн вэйбэнь* буюу хүнийг нэн тэргүүнд тавина.
2. *Сихуа Тунбү* буюу дөрвөн салбартай хамтран урагшилна. Дөрвөн салбар гэдэг нь Мэдээлэлжүүлэлт, аж үйлдвэржилт, хотжилт, хөдөө аж ахуйн орчин үежилт болно. Мөн хотын соёлтой иргэнийг төлөвшүүлнэ, байгаль орчинд ээлтэй байдлаар шийднэ, зах зээлд түшиглэнэ гэсэн зарчмуудыг баримтална гэсэн байна.²¹⁵

Хотжилтын хоёр дахь хувилбар

Хятадын хотжилтын тэсрэлтийн хоёр дахь хувилбар нь хөдөө орон нутаг дахь төв суурин газруудыг дэмжин өргөтгөж үйл ажиллагаа юм. Энэ чиглэлээр орон нутгийн төрийн байгууллагууд илүү идэвхийлэн ажиллаж байгаа болно. Ийм хувилбараар голлон хөдөөгийн жижгэвтэр хотууд *жизжун зижү* (jizhong jizhu) төвлөрсөн тосгон сууринд нягтруулан суурьшуулах үйл ажиллагаа гэсэн үг. Энэ нь бас нэлээд хотожсон маягтай болж, барилга байгууламж, дэд бүтцийн салбар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг тодорхой хэмжээгээр урагшлуулж, орон нутгийн хөрөнгө оруулалтыг дэмжин ажлын байр бий болгоно. Мөн хөдөөгийн орчинд мөнгөний эргэлтийг тодорхой хэмээнд түргэсгэнэ.

Юуны түрүүнд Хятадын хувьд шинэ хэв маягийн хотжилтын бодлогын хамгийн том бэрхшээл хүндрэл нь Хятадын хотуудад суурьшсан хийгээд хэрэн бэдэрч, нүүдэл суудал хийж буй иргэдийн тоо 260 сая гаруй байгаад оршино. Дээр нь тэдний тоо улам бүр нэмэгдэж байгаад оршино. Тухайлбал, хотын оршин суугчдын нийт тоон дахь хөдөөгийн нүүдэл иргэдийн хэмжээ 2000 онд 31 хувь байсан бол 2010 он гэхэд 42 хувь хүртэл өссөн байна.²¹⁶ Судлаачдын тооцоолсноор Хятадын нийт хүн ам дахь хотын хүн амын хувь хорин жилийн дотор 30.6 хувиар буюу эрс нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, 1990 онд 22 хувь байсан бол 2012 онд 52.6 хувь болжээ. Гэтэл хотын иргэний үнэмлэх буюу *хукоу*-тай иргэн дөнгөж 7.7 хувиар л өссөн байна.²¹⁷

ДҮГНЭЛТ

Монгол, Хятад улсын хотжилтын үйл явц нь цаашид гүнзгийрүүлэн судлууштай цогц асуудал юм. Хоёр улс адилхан бэрхшээл туулж байгаа учраас бие биенийхээ туршлагаас судлах нь зүйтэй билээ. Мөн Монголын хувьд Хятадын хотжилтын цар хүрээтэй бодлогыг судлах нь туйлын чухал болно.

Хоёр орны хувьд аль алинд нь өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой шалтгаан, тулгамдсан ярвигтай асуудлууд болон бэрхшээлүүд, шийдвэрлэх ёстой сорилтууд байгаа ч эдгээрийн даван туулах гарцаагүй арга хэмжээ нь хотжилт болно гэсэн дүгнэлтэд хүрч байна.

²¹⁵ Мөн сонин, 9-р тал.

²¹⁶ World Bank and State Council of China, *Urban China: Efficient, Inclusive, and Sustainable Urbanization* (Washington, D.C., World Bank Group, 2014) p. 113.

²¹⁷ Dan He, “Hukou System Lags behind Urbanization,” *China Daily* (30 October 2013), p.4

